



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 30

Арвайхээр

Арвайхээр 5 дугаар баг, Бурхи 9 дүгээр баг, Хүйс толгой  
11 дүгээр багийн нутаг дэвсгэрт нэмж оруулсан  
хаягийн жагсаалтыг батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2013 оны “Журам батлах тухай” 280 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Арвайхээр сумын Арвайхээр 5 дугаар багийн нутаг дэвсгэрт нэмж оруулсан хаягийн жагсаалт, зургийг нэгдүгээр, Бурхи 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт нэмж оруулсан хаягийн жагсаалт, зургийг хоёрдугаар, Хүйс толгой 11 дүгээр багийн нутаг дэвсгэрт нэмж оруулсан хаягийн жагсаалт, зургийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх багуудын "Хаягийн зураг", гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг байршуулах, шинэ хаягийн зургийг нийтийн хэрэгцээнд гаргах ажилд дээрх өөрчлөлтийг оруулан хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга /О.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН

